



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/522

Булган сум

“Жаргалант” зусланд англи хэлний  
хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, “Англи хэлтэй Булган хөтөлбөр батлах тухай” VI/33 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардал батлах тухай” A/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн хүрээнд Булган сумын Жаргалант зуслангийн 2,3 дугаар ээлжийн амрагч сурагчдад англи хэлний сургалтыг Монголын англи хэлний академитай хамтран ажиллах гэрээ байгуулан зохион байгуулж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг “Англи хэлтэй Булган” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР